# МТХ-ИЙН ДАРГА Д.ГЭРЭЛНЯМЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

Нэгжийн нэр: БТГ-ЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ХЭЛТЭС

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | Биелэлтийн хувь = (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь) | (Биелэлтийн хувь * 70 / 100%) |
| **Гүйцэтгэлийн зорилт № 1. Салбарын үйл ажиллагааг ил тод нээлттэй, түргэн шуурхай болгож бүх үйлчилгээг цахимжуулна** | | | |
| 1.1 | E-Mongolia цахим үйлчилгээний нэгдсэн порталд зам, тээврийн салбарын үйлчилгээг нэмэгдүүлэх | 100 | 70 |
| 1.2 | Цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх | 100 | 70 |
| 1.3 | Зам, тээврийн салбарын цахим үйлчилгээний төвийг ашиглалтад оруулж, үйлчилгээг гар утаснаас авах боломжийг бүрдүүлэх | 100 | 70 |
| 1.4 | “Асуудал, шийдлийн систем”-ийг хөгжүүлж иргэдийн санал, гомдлыг цахимаар авч, боловсруулан бодлого төлөвлөлтөд ашиглах | 100 | 70 |
| 1.5 | Бүх төрлийн зорчих тасалбар захиалгыг нэгдсэн системээр олгох боломжийг бүрдүүлэх | 100 | 70 |
| 1.6 | Дотоодын ачаа тээврийн нэгдсэн систем хөгжүүлэх | 90 | 63 |
| 1.7 | Салбарын тусгай зөвшөөрлийн системийн 2.0 хувилбарыг хөгжүүлэх | 100 | 70 |
| **Гүйцэтгэлийн зорилт № 2. Салбарын бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд шинэ технологи, инноваци нэвтрүүлэх туршилт, судалгаа хийнэ** | | | |
| 2.1 | Зам, тээврийн салбарт дроныг турших | 100 | 70 |
| 2.2 | Google map системтэй хамтран ажиллах | 100 | 70 |
| **Гүйцэтгэлийн зорилт 3. Яамны дотоод үйл ажиллагаанд дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэх, интернэт болон дотоод сүлжээний зохион байгуулалтыг шинэчлэнэ.** | | | |
| 3.1 | Яамны интернэт болон дотоод /тусгай/ сүлжээнүүд, юнивишн, суурин утас, цахилгаан холбооны шугам сүлжээг шинэчлэх | 100 | 70 |
| 3.2 | Дотоод удирдлагын E-Mongolia ERP системд шилжих | 100 | 70 |
| 3.3 | Ажлын цаг ашиглалтыг нэмэгдүүлэх ухаалаг хяналтын хаалга суурилуулж, программ хангамжийг хөгжүүлэх | 100 | 70 |
| 3.4 | Салбарын хүний нөөцийн мэдээллийн санг бүрдүүлэх, чадавхыг сайжруулах сургалтын систем хөгжүүлэх | 90 | 63 |
| 3.5 | Төрийн нээлттэй өгөгдлийн порталыг зам, тээврийн салбарын нэгдсэн платформтой холбох | 100 | 70 |
| 3.6 | Салбарын мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх, Харьяа байгууллагуудад мэдээллийн аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ хийлгэх | 100 | 70 |
| 3.7 | “Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ 2.0” хувилбарыг хөгжүүлэх | 100 | 70 |
| 3.8 | Улс, хот хоорондын ачаа тээврийн нэгдсэн систем, Си зөвшөөрлийн бүртгэл, хяналтын систем, Тээврийн хэрэгслийн бүртгэлийн VRS систем, Техникийн хяналтын үзлэгийн MVIS систем, Автотээврийн байцаагчийн зөрчил, бүртгэл, шийдвэрлэлтийн систем, Улсын дугаарын дуудлага худалдааны | 100 | 70 |

| | | | |
|---|---|---|---|
| | бокс нэгдсэн системүүдийг хөгжүүлж боловсронгуй болгоход талаар мэргэжил арга зүйгээр дэмжиж, ажлын уялдаа холбоог ханган ажиллах | | |
| 3.9 | Салбарын дижитал шилжилтийн хүрээнд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр ажиллах | 100 | 70 |
| 3.10 | Байгууллагын хэмжээнд ашиглагддаг компьютер, принтер, сүлжээний тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах | 100 | 70 |
| 3.11 | Байгууллагын серверийн өрөөний хэвийн ажиллагаа, хяналтын камер, дотоод сүлжээний SPARK мессенжерийн сервер бусад серверийн байнгын ажиллагааг хангах | 100 | 70 |
| 3.12 | Байгууллагын хэвлэлийн эх бэлтгэл, видео контент бэлтгэх ажлыг гүйцэтгэх | 100 | 70 |
| **Зорилго 4. Авто замын төлбөр хураамжийг төвлөрүүлэх, зам тээврийн хөдөлгөөний удирдлага, хяналтын нэгдсэн, ухаалаг систем бий болгох, дотоодын ачаа тээвэр, логистикийн платформыг хөгжүүлнэ.** | | | |
| 4.1 | АХБ-ны Техник туслалцаа “TA 6931:MON “Тээврийн мэдээллийн системийг хөгжүүлэх” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | 100 | 70 |
| 4.2 | Улаанбаатар-Алтанбулаг чиглэлийн авто замд тээврийн хяналтын системийг нэвтрүүлэх | 100 | 70 |
| 4.3 | Авто замын орон зайн мэдээллийн системийг Үндэсний орон зайн мэдээллийн системтэй холбох | 100 | 70 |
| 4.4 | Авто замын зураг төсөл, техникийн магадлалын мэдээллийн санг хөгжүүлж, мэдээлэл, лавлагааны систем хөгжүүлж эхэлнэ. | 70 | 49 |
| 4.5 | RFID технологи дээр суурилсан “Зам, тээврийн нэгдсэн систем” -ийн ерөнхий архитектурыг тодорхойлж, зам, тээврийн нэгдсэн системийг хөгжүүлэх ажлын даалгаврт тусгах техникийн болон програм хангамжийн шаардлагуудыг боловсруулах | 100 | 70 |
| 4.6 | Авто замын төлбөр хураах цэгийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, шинэ дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэх ажлын даалгаварт тусгах техникийн болон програм хангамжийн үзүүлэлт, шаардлагуудыг тодорхойлох | 90 | 63 |
| 4.7 | Яамны цахим хуудасны англи, монгол хувилбарыг шинэчлэх, монгол бичгээр мэдээ нийтэлдэг болгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй болгох | 100 | 70 |
| | **ДУНДАЖ** | | **68.5** |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Цахим шилжилтийн чиглэлээр семинар, сургалтад хамрагдаж, ур чадвараа дээшлүүлнэ | 100 | 15 |
| 2. | Мэдээллийн аюулгүй байдлын мэргэшүүлэх сургалтад хамрагдах | 100 | 15 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | **15** |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагч өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 14 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 12 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 13 |
| 4. | Манлайлах | 14 |
| 5. | Багаар ажиллах | 14 |
| 6. | Харилцаа | 14 |

| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
|---|---|---|
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 2. | |
| 9. | Мэргэжлийн ур чадвар 3. | |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 13.5 |

4. **Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)* | 88.5 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)* | 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)* | 13.5 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =**<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 97.0<br>80.4 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга:***

**Бодлого, төлөвлөлтийн газрын**

**дарга** .............................. **/ Б.Артур /**

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024/12/06 (огноо)

9024070495 5919487 СБА 12283

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Нэгжийн дарга:***

**Мэдээллийн технологийн**

**хэлтсийн дарга** .............................. **/Д.Гэрэлням/**

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(огноо)*

2024.12.06

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТ**

| № | Зорилт, арга хэмжээний нэр | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Гүйцэтгэлийн зорилт № 1. Салбарын үйл ажиллагааг ил тод нээлттэй, түргэн шуурхай болгож бүх үйлчилгээг цахимжуулна** | | | | | | |
| 1.1 | E-Mongolia цахим үйлчилгээний нэгдсэн порталд зам, тээврийн салбарын үйлчилгээг нэмэгдүүлэх | Нэмсэн үйлчилгээний тоо | 26 үйлчилгээг нэвтрүүлсэн. | **I улирал:** Порталд оруулах салбарын үйлчилгээг тодорхойлно.<br><br>**II улирал:** Порталд холбох бэлтгэлийг хангана.<br><br>**III улирал:** Гурваас доошгүй үйлчилгээг порталд оруулна.<br><br>**IV улирал:** Нийт 5-аас доошгүй үйлчилгээг порталд оруулна. | Нэгдүгээр улиралын байдлаар зам, тээврийн салбарын 26 үйлчилгээг E-Mongolia порталд байршуулсан байна. 2 дугаар сард олон улс, улсын чанартай авто зам ашигласны төлбөрөөс чөлөөлөгдөх хүсэлт шийдвэрлэх үйлчилгээг оруулсан. Нэмэлтээр 4 үйлчилгээг оруулахаар бэлтгэл хангаад байна. 1. Авто замын орц, гарц, сэтгэх зөвшөөрөл, овор ихтэй ачааны тээврийн зөвшөөрөл, даац хэтрэх задардаггүй ачаа тээвэрлэх зөвшөөрөл хүсэх зэргийг оруулахаар төлөвлөсөн. Мөн харьяа байгууллагуудаас E-Mongolia порталд оруулах боломжтой үйлчилгээний жагсаалт гаргуулахаар албан бичиг хүргүүлж цахимаар санал авсан. Зам, тээврийн салбараас E-Mongolia порталд 5 үйлчилгээ нэмж оруулсан.1. Авто замын орц, гарц, сэтгэх зөвшөөрөл, овор ихтэй ачааны тээврийн зөвшөөрөл, даац хэтрэх задардаггүй ачаа тээвэрлэх зөвшөөрөл хүсэлт шийдвэрлэх, иргэний агаарын хөлгийн засвар, үйлчилгээ эрхлэх, иргэний агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа эрхлэх, иргэний нисэхэд ашиглах аэродром, нисэх буудлын үйлчилгээ эрлэх тусгай зөвшөөрөл хүсэх үйлчилгээнүүдийг оруулсан. Мөн автотээврийн хэрэгслийг цахимаар шилжүүлэх цахим хүсэлтийг E-mongolia болон Autobox системд нэвтрүүлсэн. | 2024.01.01-2024.12.31 | 100 |



67

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2 | Цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх | Цахим үйлчилгээний эзлэх хувь | Салбарын 94 үйлчилгээ, үйл ажиллагаag цахимжуулсан. | **I улирал:** Цахим үйлчилгээ бүрээр суурь түвшинг тодорхойлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх судалгаа хийж, салбарт шинээр цахимжуулах үйлчилгээний төлөвлөгөө батлуулна.<br><br>**II улирал:** Төлөвлөгөөний дагуу шинээр цахимжуулах ажлын гүйцэтгэлийг 30-с доошгүй хувьд хүргэж, цахим үйлчилгээний хувийг суурь түвшингээс 10-аас доошгүй хувиар өсгөнө.<br><br>**III улирал:** Цахим үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаа гаргаж, үйлчилгээний хувийг суурь түвшингээс 20-аас доошгүй хувиар өсгөнө.<br><br>**IV улирал:** Цахим үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаа гаргаж, үйлчилгээний хувийг суурь түвшингээс 30%-иас доошгүй өсгөж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 90-ээс доошгүй хувьд хүргэнэ. | Салбарын цахим үйлчилгээний суурь түвшинг тодорхойлох судалгааг мэдээллийн нэгдсэн платформд Veritech ERP (mrtd.gov.mn) холбоосоор байршуулж, програмын судалгааг авч, үйлчилгээний суурь түвшинг тодорхойлсон. Шинээр цахимжуулах болон цахимжуулалтын чиглэлээр ажиллах нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж харьяа байгууллагуудад 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 03/565 дугаартай албан бичгийг хүргүүлж, хариуд ирүүлсэн саналыг үндэслэн цахимжуулах үйлчилгээний төслийг боловсруулж, батлуулсан. Овор ихтэй, хүнд ачааны зөвшөөрлийг цахимаар олгож эхэлсэн ба e-zam.mn, roadpay.mn системээр хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэдэг болов. Тээврийн хэрэгслийн улсын дугаар захиалгыг Autobox системээр дамжуулан нийт 26 үйлчилгээг цахимаар авч, нийт цахим үйлчигээг 30 хувиар өгсөсөн. Хуучин burtgel.transdep.mn системийг сайжруулах саналыг боловсруулсан. Тээврийн хэрэгслийг цахимаар шилжүүлэх үйлчилгээг Autobox системд амжилттай туршиж, үйлчилгээнд нэвтрүүлэв. Биелэлт 100% | 2024.01.01-2024.12.31 | 100 |
| 1.3 | Зам, тээврийн салбарын цахим үйлчилгээний төвийг ашиглалтад оруулж, үйлчилгээг гар утаснаас авах боломжийг бүрдүүлэх | Гар утаснаас авах үйлчилгээний тоо | 5 аппликейшн нэвтрүүлсэн. | **I улирал:** Салбарын цахим үйлчилгээний төвийг ТХХТ-ээр байгуулахаар холбогдох хууль, журмын дагуу гэрээг байгуулна. Салбарын цахим үйлчилгээг гар утаснаас авах хувилбарт шилжүүлэх судалгааг хийнэ.<br><br>**II улирал:** Салбарын цахим үйлчилгээний төвийг ашиглалтад оруулж, үйлчилгээний 20 хувийг иргэд гар утаснаасаа авдаг болгоно. | Яамны Б байрны 1 дүгээр давхарт засвар хийж Зам, тээврийн салбарын цахим үйлчилгээний “eRThub” төв байгуулж ашиглалтад оруулах хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдийг хамтран ажиллах урилгыг 2 удаа яамны цахим хуудсанд зарласан. https://mrtd.gov.mn/i/3915 Мөн сонгон шалгаруулалтыг хийх ажлын хэсгийг ТНБД-ын 2024 оны А/28 дугаар тушаалаар байгуулсан. Яамны өргөтгөл Б байрны тухай хэсэгт засвар хийж хамтран ажиллах хувийн хэвшил материал ирүүлээгүй тул яам дотоод бололцоогоороо бүх тоног төхөөрөмжүүдээ аваад байна. Мөн НҮБХХ-т хандан албан бичгээр хүсэлт гаргасан. Түүний дараaa аж ахуйн нэгж сонгон шалгаруулах зарыг дахин 2 удаа сунгаж “Юуком | 2024.01.01-2024.12.31 | 100 |



68

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | **III улирал:** Салбарын цахим үйлчилгээний 40 хувийг иргэд гар утаснаасаа авдаг болно.<br><br>**IV улирал:** Салбарын цахим үйлчилгээний 60 хувийг иргэд гар утаснаасаа авдаг болно. | групп" ХХК санал ирүүлсэн. Гэрээ байгуулах ажил хийгдэж байна.<br>Зам, тээврийн салбарын үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд салбарын цахим үйлчилгээг гар утаснаас авах хувилбарт шилжүүлэн иргэд, олон нийт, харилцагчид зам, тээврийн салбарын салбарын AutoBox, SmartCar, e-Logistic, UBSmartBus, TeeverZuuch, TapaTrip, PapaLogistic, AbaTaxi, UbCab, ToGo, UBParking, MIAT-Airlines, Nisleg, UBTZTicket, E-Normative, AutoZam, iMap, NaviMarket, GeoNet зэрэг 30 гаруй аппликейшн ашиглалтад бүрэн оруулж, чирэгдэлгүй, түргэн шуурхай үйлчилгээ авч байна. Энэ нь салбарын цахим үйлчилгээний 40 гаруй хувьд хүрээд байна. | | |
| 1.4 | "Асуудал, шийдлийн систем"-ийг хөгжүүлж иргэдийн санал, гомдлыг цахимаар авч, боловсруулан бодлого төлөвлөлтөд ашиглах | Төслийн хэрэгжилтийн явц | Төлөвлөлтийн шат | **I улирал:** Уг системийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх Ажлын хэсгийг байгуулж, төлөвлөгөө гаргана.<br><br>**II улирал:** Уг системийг бусад системүүдтэй интеграцлах гэрээ байгуулж, ерөнхий архитектурыг боловсруулна.<br><br>**III улирал:** Ерөнхий архитектурын дагуу хөгжүүлэлт хийх гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, ажлыг эхлүүлнэ.<br><br>**IV улирал:** Системийг туршин, нэвтрүүлж, холбогдох асуудал, шийдлийг бодлогод тусгана. | • ТНБД-ын 2024.04.04-ны өдрийн А/59 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулсан.<br>• Системийн ерөнхий архитектураа боловсруулж, гүйцэтгэгчтэй 2024.05.30-ны өдрийн №ЗТХТ/20240203057 тоот зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан. Уг гэрээний дагуу яам, гүйцэтгэгч Интерактив ХХК-тай 2024.06.05-ны өдөр хийх ажлын төлөвлөгөөгөө баталж ажлаа эхлүүлсэн.<br>• Системийг Засгийн газрын 1111 төвтэй мэдээлэл солилцох хүрээнд уулзалт зохион байгуулж, Үндэсний дата төв дээрх сервер дээр портуудаа нээж, вэб сервисээ хөгжүүлж, мэдээлэл солилцож байна. Төлөвлөгөөний дагуу системийн хөгжүүлэлт хийгдэж, турших байна.<br>• Гүйцэтгэгч компаниас хөгжүүлсэн системээ 2024.11.22-нд яамны холбогдох албан хаагч нарт танилцуулж, санал хүсэлтийг нь авч, түүний дагуу засварууд хийж, ТЗУГ-ын Б.Хонгорзулд заавар өгч, системийн эрхийг нь нээж өгсөн. | 2024.01.01-2024.12.31 | 100 |
| 1.5 | Бүх төрлийн зорчих тасалбар захиалгыг нэгдсэн системээр | Ажлын явц, хувиар | Хувийн хэвшил систем хөгжүүлсэн | **I улирал:** Холбогдох системүүдийг харьцуулан судалж, сонгосон системийг харьяа байгууллагуудын | Бүх төрлийн зорчих тасалбар захиалгыг нэгдсэн системээр олгох боломжийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох системүүдийг харьцуулан судалж, сонгосон системийг харьяа | 2024.01.01-2024.12.12 | 100 |



69

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | олгох боломжийг бүрдүүлэх | | | тасалбар захиалгатай интеграцлах боломжийг судална.<br><br>**II улирал:** Судалгаанд үндэслэн систем хөгжүүлэх ажлын даалгавар боловсруулж, батлуулна.<br><br>**III улирал:** Систем хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ.<br><br>**IV улирал:** Бүх төрлийн зорчих тасалбар захиалгыг нэгдсэн системээр олгох боломжит маршрутыг зорчигчдод мэдээллэх ажлыг туршина. | байгууллагуудын тасалбар захиалгатай интеграцлах хүрээнд тасалбар борлуулалтын нэгдсэн системийг хөгжүүлэхээр ТНБД-аар удирдуулан харъяа байгууллагууд болон тийз борлуулалтын агентуудтай 2 удаа уулзалт хийв. Уг судалгаанд хамрагдсан холбогдох талууд, салбар, байгууллагуудын хүрээнд шийдэлд хүрэхээр түвшиний уулзалт, хэлэлцүүлэгийг зохион байгуулж, ТНБД дараах 2 үйл ажиллагаag хэрэгжүүлэхээр эцэслэн тохиролцож, шийдвэрлэв. Үүнд:<br>1. Иргэний нисэх, автотээвэр, төмөр замын маршрут сонголтыг систем хооронд интеграци хийн нэгтгэн харуулах;<br>2. Тасалбарын үнийг зээл авч, хувааж төлөх зэрэг боломжуудыг бүрдүүлэх;<br>3. “Mon Air Tour” ХХК-тай хамтын ажиллагааны хүрээнд mTrip app шинээр хөгжүүлэхээр тохиролцсон.<br>Өнөөдрийн байдлаар АТҮТ, УБТЗ-ын зорчигч тээврийн системээс веб сервисийн холболт хийхээр ажиллаж байна.<br>Судалгааны хүрээнд олон улсын IATA-гийн гишүүн орнуудын эрх бүхий Агаарын тээврийн билет борлуулалтын агентуудын ашигладаг Амедус системийг шууд хэрэглэх шийдвэр гарч, уг систем ажиллаж байгаа ба зам, тээврийн салбарын холбогдох үйл ажиллагааны Mtrip төв үйл ажиллагаагаа эхлүүлэн, иргэдэд үйлчилж байна. | | |
| 1.6 | Дотоодын ачаа тээврийн нэгдсэн систем хөгжүүлэх | Ажлын явц, хувиар | Төлөвлөлтийн шат | **I улирал:** “АТҮТ” ТӨҮГ-ын дотоодын ачаа тээврийн систем, “МАТНХ” ТББ-ын тээвэр зуучын систем, хувийн хэвшлийн системүүдийг “Юү эл пи ди ХХК”-ын хөгжүүлсэн “e-logistics.mn” системтэй интеграцчлах судалгааг хийнэ.<br>**II улирал:** Дотоодын ачаа тээврийн нэгдсэн системийг хөгжүүлэх ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлж эхэлнэ. | ”ТӨҮГ-ын дотоодын ачаа тээврийн систем, “МАТНХ” ТББ-ын тээвэр зуучын систем, хувийн хэвшлийн системүүдийг “Юү эл пи ди” ХХК-ын хөгжүүлсэн системтэй интеграцчлах судалгааг хийж, санал дүгнэлт боловсруулсан. ЗТНС-д “АТҮТ” ТӨҮГ-ын logistics.transdep.mn системийг холбосон. Мөн “Юү эл пи ди” ХХК-ийн хөгжүүлсэн e-logistics.mn системийг холбохоор системийн тохиргоог хийсэн.Автотээврээр зорчигч, ачаа тээвэрлэх дүрмэнд өөрчлөлт оруулах, ачаа тээврийн үйл ажиллагааны зураглал батлуулах ажлыг АТБЗГ-аас хэрэгжүүлсэн. | 2024.01.01-2024.12.12 | 90 |


70

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | **III улирал:** Салбарын ачаа тээврийн нэгдсэн мэдээ боловсруулах ажлыг цахимжуулж, салбарын нэгдсэн платформд холбож дотоодын ачаа тээврийн статистик мэдээг цахимаар нэгтгэнэ.<br>**IV улирал:** Дотоодын ачаа тээврийн үйлчилгээг гар утаснаас авах боломжийг бүрдүүлсэн байна. Ачааны байршил мэдээллийг лавлах үйлчилгээг мобайл апп ашиглан туршина. | | | |
| 1.7 | Салбарын тусгай зөвшөөрлийн системийн 2.0 хувилбарыг хөгжүүлэх | Ажлын явц, хувиар | Одоо ажиллаж байгаа системүүд | **I улирал:** Системийн шинэчилсэн хувилбар хөгжүүлэх ажлын даалгавар боловсруулж, батлуулсан байна;<br><br>**II улирал:** Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, хөгжүүлэлтийн ажлыг 30%-д хүргэнэ.<br><br>**III улирал:** Хөгжүүлэлтийн ажлыг 80%-д хүргэнэ.<br><br>**IV улирал:** Хөгжүүлэлтийн ажлыг 100%-д хүргэж, нэвтрүүлсэн байна. | ЗТЯ нь "Зөвшөөрлийн тухай хууль"-ийн 8.1 дүгээр зүйлийн 5.1-5.8-д заагдсан тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд 2021 онд хөгжүүлсэн цахим систем (license.mrtd.gov.mn)-ээрээ дамжуулж ААН-ээс ирсэн хүсэлтийг бүртгэх, хянах, олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагааг цахимжуулсан. Засгийн газрын 2023 оны 251 дүгээр тогтоолоор батлагдсан “Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөх журам”-ын дагуу и-Монгол академийн хөгжүүлсэн eBusiness нэгдсэн платформ дээр салбарын тусгай зөвшөөрөл, энгийн зөвшөөрлүүдийг оруулахаар 2023.03.19-ний өдрийн 03/1133 албан бичгээр ЦХХХЯ болон И-Монгол академи руу илгээсэн дагуу манай салбарын тусгай болон энгийн зөвшөөрлүүдийг цахимжуулах бодлогын даалгавар боловсруулж, даалгаврын дагуу Авто замд орц гарц гаргах, сэтлэх, сүвлэх зөвшөөрлийг цахимжуулах ажлыг хийв. Мөн eBusiness нэгдсэн платформд Авто зам барих, төмөр замын тусгай зөвшөөрлийг оруулан хөгжүүлж, эхний хувилбар гарсан. | 2024.01.01-2024.12.31 | 100 |

**Гүйцэтгэлийн зорилт № 2. Салбарын бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд шинэ технологи, инноваци нэвтрүүлэх туршилт, судалгаа хийнэ**



71

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1 | Зам, тээврийн салбарт дроныг турших | Салбар дроны хэрэглээг нэвтрүүлэх туршилт | Зам, тээврийн салбарт дроныг хэрэглэх суурь тогтолцоо бүрдсэн байна | **I улирал:** Салбарт дроныг ашиглах боломжийн талаарх судалгаа хийнэ. Дрон ашиглаж төслийн явцыг хянах эрхзүйн зохицуулалтыг судална.<br><br>**II улирал:** Салбарын бүтээн байгуулалтын төслийн явцыг хянан туршина.<br><br>**III улирал:** Зам, тээврийн салбарын үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх зорилгоор туршина.<br><br>**IV улирал:** Салбарын бүтээн байгуулалтыг дроноор хянаж төслийн програмд мэдээлэл дамжуулах ажлыг хийнэ. | Зам, тээврийн салбарт дрон ашиглан төслийн явцыг хянах боломжийн талаар дрон худалдаалагч байгууллага, хувь хүмүүсээс зөвлөгөө авч санал солилцсон. Мөн “Инженер Геодези“ ХХК-аас зохион байгуулсан нээлттэй семинарт оролцон эрхзүйн зохицуулалтын талаар мэдээлэл авч, зам, тээврийн салбарт ашиглаж болох дроны судалгааг боловсруулан, худалдан борлуулагч талуудаас үнийн санал авсан. Авто замын орон зайн мэдээллийн системд дрон хяналтын зураг, бичлэг оруулах систем хөгжүүлэлт хийгдэж байгаа ба энгийн дроноор авсан зураг оруулах туршилт хийсэн. Азийн хөгжлийн банкны хөрөнгөөр санхүүжилт шийдвэрлэгдэж дрон худалдан авах тендер зарлагдсан боловч шалгарсан компани нь тоног төхөөрөмжийг нийлүүлэх боломжгүй болж ажил зогссон. | 2024.01.01-2024.12.31 | 100 |
| 2.2 | Google map системтэй хамтран ажиллах | Google map системд оруулсан мэдээллийн чанар, тоо хэмжээ | Google map-д зам, тээврийн салбарын холбогдох мэдээллүүд орсон. | **I улирал:** Зам, тээврийн салбарт Google map систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, ажлын даалгаврыг батлуулна.<br>**II улирал:** Батлагдсан ажлын даалгаврын 50 хувийг гүйцэтгэнэ.<br>**III улирал:** Батлагдсан ажлын даалгаврын 70 хувийг гүйцэтгэнэ.<br>**IV улирал:** Батлагдсан ажлын даалгаврын 100 хувийг гүйцэтгэнэ.. | Ажлын даалгавар 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлагдсан. Гүйцэтгэгч компаниар “И-ТЕХ” ХХК шалгарч, санхүүжилтийг ЗТЯ, “ЗТХТ” ТӨҮГ, “АТҮТ” ТӨҮГ байгууллагууд хамтран шийдвэрлэхээр болсон. Ажил гүйцэтгэх гэрээг 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр байгуулсан. Тус ажлыг 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Байгаль орчин аялал жуулчлалын яам болон Зам, тээврийн яамны удирдлагууд оролцож албан ёсоор нээсэн. Ажлын даалгаварт тусгасан маршрутын дагуух 360 панорама зураг, замын хажуугийн байгууламжийн мэдээллүүд системд бүрэн орсон. Ажлын тайланг гүйцэтгэгч компаниас 2024 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр хүлээж авсан. Батлагдсан ажлын даалгаврыг 100% хийж гүйцэтгэсэн. | 2024.01.01-2024.12.31 | 100 |
| **Гүйцэтгэлийн зорилт 3. Яамны дотоод үйл ажиллагаанд дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэх, интернэт болон дотоод сүлжээний зохион байгуулалтыг шинэчлэнэ.** | | | | | | | |
| 3.1 | Яамны интернэт болон дотоод | Сүлжээний аюулгүй, | Холбогдох ажлын | **I улирал:** Дотоод сүлжээг шинэчлэх ажлыг эхлүүлж, | Яамны сүлжээний зохион байгуулалт шинэчлэх ажлын даалгаврыг 2023 оны 12-р сарын 14-ний | 2024.01.01-2024.12.31 | 100 |


72

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | /тусгай/ сүлжээнүүд, юнивишн, суурин утас, цахилгаан холбооны шугам сүлжээг шинэчлэх | найдвартай, хэвийн ажиллагаа хангагдсан эсэх<br><br>Интернэтийн хурд 150mpbs | даалгавар батлуулсан | шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авч, суурилуулна.<br><br>**II улирал:** Интернэт, дотоод сүлжээ, юнивишн, суурин утас, цахилгаан холбооны шугам сүлжээг шинэчилж дуусгана.<br><br>**III улирал:** Сүлжээний аюулгүй, найдвартай, хэвийн ажиллагааг хангаж, топологи зураглал бүхий заавар боловсруулна.<br><br>**IV улирал:** Дотоод сүлжээ, серверийн өрөө, галт ханыг мэдээллийн аюулгүй байдлын стандарт, шаардлагын дагуу ажиллуулна. | өдөр ТНБД-ын АУТОГ ТЗУГ-ийн даргаар батлуулж, 2024 оны 03-р сарын 28-ний өдөр ажил гүйцэтгэх гэрээг “Төгс Итгэл Бүтээмж” ХХК-тай байгуулан, яамны дотоод сүлжээг шинэчлэх ажлыг хийж байна. Ажлын даалгаварт заасны дагуу Амралтын өдөр болон ажлын бус цагаар шинээр дотор зориулалтын cat6e болон түүнтэй дүйцэхүйц 98%-иас дээш зэсийн агууламжтай кабел ашиглан давхар бүрт 48port-н свичийг зориулалтын рак-д байршуулан түүнээс хэрэглэгчид очих кабелийг 4 хүнээс доош хэрэглэгчтэй өрөөнд шууд кабель татаж 4 болон түүнээс дээш хэрэглэгчтэй өрөөнд 5-16 порттой 10-100-1000mpbs свич тавьж, өрөө тус бүрт нэг илүү нөөцийн кабель татах зэргээр ажлуудыг холбогдох графикийн дагуу гүйцэтгэсэн. | | |
| 3.2 | Дотоод удирдлагын E-Mongolia ERP системд шилжих | Байгууллагын дотоод үйл ажиллагааны ERP системийн хэвийн ажиллагаа хангагдсан эсэх,<br><br>Яамны олон нийттэй харилцах эргэх холбооны үнэлгээ | ERP системүүдийг харьцуулан судалж, мэдээллийн урсгалд үнэлгээ хийж, дүгнэлт гарган, системийг шинэчлэх, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хэрэглээний программуудыг лицензжүүлэх төлөвлөгөө батлуулсан. | **I улирал:** Бүх албан хаагчдыг E-Mongolia ERP системд бүртгэж, Office 365-ыг хэрэгцээ, шаардлагаас хамааруулан 30 хэрэглэгчид эрх олгож, нэвтрүүлнэ.<br>**II улирал:** Тоон гарын үсгийн гэрчилгээ, токен тохируулж, төрийн албан бичиг солилцооны системд холбож, цахимаар албан бичиг солилцох боломжийг бүрдүүлнэ. Чатбот, калл про болон яамны бүх системүүдийн үйл ажиллагааг уялдуулан сайжруулна.<br>**III улирал:** E-Mongolia ERP систем дээр албан хэрэг хөтлөлт, төлөвлөлт, хүний нөөц, албан үүргийн модуль зэрэг программуудыг хэрэглэх заавар өгч, нэвтрүүлнэ. | Яамны бүтцийн дагуу газар, хэлтэс, албан тушаал, албан хаагчдын мэдээллийг системд бүрэн оруулж албан хаагчдад нэвтрэх нэр, нууц үгийг э-мэйлээр хүргүүлсэн. Office 365 системийн албан хаагчдын хэрэгцээ шаардлагаас хамааруулан 26ш лицензийг газар бүрийн сонгогдсон албан хаагчдын компьютерт суулгаж нэвтрүүлсэн. Яамны нийт 24 /удирдлага/ албан хаагчдыг токен болон гэрчилгээг тохируулан хүлээлгэн өгсөн. Төрийн байгууллагуудын хоорондын албан бичиг солилцооны дундын DocX системийн тохируулгыг Эйбл системд бүрэн хийснээр цахимаар албан бичиг илгээх, хүлээн авах бүрэн боломжтой болгосон. Чатбот системийг яамны цахим хуудас болон Facebook хаягтай холбож иргэдээс ирсэн асуултад зохих мэдээллээр хангах анхан шатны сайжруулалтыг хийсэн. Тус онд Callpro системээр 2024 оны 11 дүгээр сарын 15-ны байдлаар 9000 гаран дуудлагыг авч хариулт өгч ажилласан байна. Яамны хэмжээнд идэвхтэй дугаарын тоо 9 байна. E-Mongolia ERP системийг ашиглах гарын авлагаар нийт албан | 2024.01.01-2024.12.31 | 100 |



73

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Яамны цахим хуудсыг шинэчлэж, хөгжлийн бэрхшээлтэй ээлтэй болгох ажлыг эхлүүлнэ.<br>**IV улирал:** Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлж, цахимаар албан бичиг солилцон, цаасны хэрэглээг бууруулна. | хаагчдыг хангасан бөгөөд бичиг хэрэг, хүний нөөцийн ажилтнуудыг тусгайлан сургалтад хамруулж ажилласан. Нэвтрүүлэлтийг бүрэн хийхэд систем талаас бичиг хэргийн модульд нэмэлт сайжруулалт хийх шаардлагатай болж И-Монгол академи УТҮГ-д хүсэлтээ хүргүүлсэн боловч хөгжүүлэлт удаашралтай байгаагаас үүдэж одоо байгаа Эйбл системийг сайжруулж үргэлжлүүлэн ашиглахыг удирдлагуудаас үүрэг болгосон. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэлийн 3-т "Төрийн байгууллагын gov.mn нэгдсэн цахим хуудсыг нэвтрүүлэх..." гэж заасны дагуу хөгжлийн бэрхшээлттэй иргэдэд ээлтэй байх хөгжүүлэлтийн ажлыг нэгдсэн байдлаар И-Монгол академи УТҮГ-аас хариуцан хийж байна. Эйбл систем ашиглан яамны нийт удирдлагууд тоон гарын үсгээр албан бичигт өөрийн токен төхөөрөмжийг ашиглан баталгаажуулалт хийж албан бичиг илгээж байна. | | |
| 3.3 | Ажлын цаг ашиглалтыг нэмэгдүүлэх ухаалаг хяналтын хаалга суурилуулж, программ хангамжийг хөгжүүлэх | Албан хаагчдын цаг ашиглалтын түвшингийн өөрчлөлт | Тоног төхөөрөмж худалдаж авсан. Систем хөгжүүлэгч компанитай гэрээ байгуулсан. | **I улирал:** Системийг бүрэн нэвтрүүлж ашиглалтад оруулж, Албан хаагчдад смарт үнэмлэх өгнө. | Яамны ажлын байрны үүдэнд шилэн хаалт, царай танигчтай хаалтын хамт шинэчлэн байршуулсан. Албан хаагч, зочны нэвтрэх үнэмлэхийг хэвлэж ашиглалтад хүлээлгэн өгсөн. Эйбл системийн цаг бүртгэлийн модульд нэмэлт хөгжүүлэлт хийж цагийн хүсэлт, тайланг илүү нарийвчлалтай авдаг болсноор албан хаагчдын цаг ашиглалт нэмэгдсэн, хоцролт багассан үзүүлэлттэй байна. Системийн хөгжүүлэлт 100%-ийн гүйцэтгэлтэй хийгдэж дууссан. Хаалтын системийг Эйбл системийн цаг бүртгэлийн модультай холболт хийхээр Эйбл талын вебсервис хөгжүүлэлт хийгдэж дууссан. Мөн албан хаагчдад тусгайлан зориулсан цаг бүртгэлийн аппликейшны хөгжүүлэлт бүрэн хийгдэж дууссан. Төсөв батлагдаж худалдан авалтыг хийхээр хүлээгдэж байна. | 2024.01.01-2024.12.31 | 100 |


71

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
